



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/575

Чингис хот

Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.7, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлагийн бүтэц орон тоог шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоолоор Худалдан авах ажиллагааны албатай байхаар заасан тул алба байгуулах зорилгоор одоо байгаа орон тоонд багтаан байгууллагын бүтэц, орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тоог мөрдүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/79 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012576

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

